



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 30 одор

Дугаар A/111

Улаанбаатар хот

Г Шаардлага батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын сургалтын байгууллагын удирдлагын системд тавих шаардлагыг нэгдүгээр, суралцахуйн удирдлагын системд тавих шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Системд бүртгэгдэх, системээр дамжих, мэдээллийн санд хадгалагдах мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах болон систем хооронд цахим мэдээлэл солилцох үйл ажиллагаанд зохих хууль тогтоомжийг баримтлан ажиллахыг сургалтын байгууллагын нийт удирдлагад даалгасугай.
3. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан шаардлагын дагуу систем ашиглахад арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Цахим бодлого, статистикийн хэлтэс /Ю.Алтантуяа/-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

. 142210382

## БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН СИСТЕМД ТАВИХ ШААРДЛАГА

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. “Боловсролын сургалтын байгууллагын удирдлагын систем” /цаашид “удирдлагын систем” гэх/ гэж суралцагч, багш, ажилтныг бүртгэх, суралцагчийг анги бүлэгт хуваарилах, хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх түүнийг удирдах, зохицуулах, сургалтын үйл явцын мэдээлэл болон суралцагчийн сурлагын амжилтын үнэлгээг бүртгэх, хянах, тайлгахаа зориулалт бүхий мэдээллийн системийг ойлгоно.

1.2. Төрийн болон төрийн бус өмчийн бүх түвшний сургалтын байгууллага болон мэдээлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийн сургалт, үйл ажиллагаанд зориулан хөгжүүлсэн удирдлагын систем нь энэхүү шаардлагад нийцсэн байна.

### Хоёр. Удирдлагын системд тавих үндсэн шаардлага

Удирдлагын систем нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын ажлын зохион байгуулалт, суралцагчийн мэдээлэл, багшийн удирдлага гэсэн бүрдэл хэсэгтэй байна.

2.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө хэсэгт доор дурдсан мэдээллийг бүртгэнэ.

2.1.1. тухайн түвшний анги/бүлгийн сургалтын хөтөлбөрийг хичээл бүрээр;

2.1.2. сургалтын төлөвлөгөөг хичээл бүрээр (7 хоногт болон жилд судлах нийт цаг);

2.1.3. үнэлгээний арга, хэрэгсэл, шалгуур;

2.1.4. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд заавал ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн (биет болон зурагт үзүүлэн, хэвлэмэл материал, туршилт, дадлагын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл)-ий жагсаалт болон нээлттэй эх сурвалжийн холбогдох линк;

2.1.5. дижитал үзүүлэн, цахим ном, сурах бичиг, гарын авлагыг файл хэлбэрээр хавсаргах боломжтой байх.

2.2. Сургалтын ажлын зохицуулалт хэсэгт доор дурдсан мэдээллийг бүртгэнэ.

2.2.1. хичээлийн жил эхлэх, үргэлжлэх, дуусах болон улирлын амралтын хугацааг;

- 2.2.2. ээлжит хичээлийн үргэлжлэх хугацааг;  
2.2.3. анги, бүлэг бүрийг бүртгэх, суралцагчийн анги бүлэгт хуваарилдаг байх;
- 2.2.4. сургалтын хэлбэрийг (өдөр, орой, эчнээ);  
2.2.5. анги, бүлэг бүрийн хичээллэх ээлжийг бүртгэх, ээлж өөрчлөгдөх тохиолдолд өөрчлөлтийг тухай бүрд нь бүртгэх зохицуулалттай байх;
- 2.2.6. хичээлийн хуваарийг анги, бүлэг бүрээр хичээл заах багшийн нэрийн хамт бүртгэж ашиглах боломжтой байх.
- 2.3. Суралцагчийн мэдээлэл хэсэгт доор дурдсан мэдээллийг бүртгэнэ.
- 2.3.1. холбогдох хууль тогтоомж, шийдвэрт заасны дагуу суралцагчийг;  
2.3.2. сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу суралцагчийг;  
2.3.3. суралцагчийн төлөв, өөрчлөлт; (суралцаж байгаа, эсхүл чөлөөтэй болон идэвхгүй зэрэг)
- 2.3.4. суралцагчийн шилжилт хөдөлгөөн;  
2.3.5. суралцагчийн элсэлт, анги дэвших болон давтан суралцах үйл ажиллагаа;
- 2.3.6. суралцагчийн төгссөн талаарх мэдээлэл;  
2.3.7. суралцагч хичээл сонголт хийх боломжтой байх.
- 2.4. Багшийн удирдлагын хэсэг хэсэгт доор дурдсан мэдээллийг бүртгэнэ.
- 2.4.1. удирдсан ангийн суралцагчийн мэдээллийг хянах, өөрчлөлт хийх;  
2.4.2. хичээл зааж байгаа анги, бүлгийн суралцагчийн дүнгийн мэдээллийг хянах, удирдах;
- 2.4.3. сургалтын баримт бичиг /журнал, суралцагчийн хувийн хэрэг/ хөтлөх;
- 2.4.4. суралцагчийн хичээлд хамрагдалтын ирцийг хичээл, цаг бүрээр;  
2.4.5. явцын үнэлгээ, хагас жилийн болон хичээлийн жилийн эцсийн дүн (голч);
- 2.4.6. анги дэвших болон улсын шалгалтын дүнг.

### **Гурав. Удирдлагын системд тавих тусгай шаардлага**


- 3.1. Сургалтын байгууллагын хэв шинжийг бүртгэдэг байх
- 3.2. Боловсролын байгууллагын удирдах ажилтны модультай байх;
- 3.3. Байгууллагын багш, ажилтны бүртгэл хөтөлдөг байх;
- 3.4. Ажилтны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийдэг байх;
- 3.5. Ажилтны төлөв, өөрчлөлтийг бүртгэдэг байх;
- 3.6. Систем хэрэглэгчийн бүртгэл, баталгаажуулалт хийдэг байх;
- 3.7. Хэрэглэгчийн эрхийг тохируулах, түдгэлзүүлдэг байх;
- 3.8. Хэрэглэгчийн системд хийх үйлдлийг тохируулдаг байх;
- 3.9. Сургалтын үйл ажиллагааны тайлан гардаг байх;
- 3.10. Тайлан экспорт хийдэг байх;
- 3.11. Санал, асуулгын хэсэгтэй байх;
- 3.12. Систем нь хайлтын функцтэй байх;
- 3.13. Хэрэглэгчийн интерфейс нь Монгол хэл дээр байх;
- 3.14. Удирдлагын систем нь ашиглах заавар гарын авлагатай байх;

3.15. Удирдлагын системд ашиглаж байгаа нэр томьёог боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан агуулгаар ойлгож хэрэглэх бөгөөд нэр томьёо өөрчлөгдөх тохиолдолд системд холбогдох өөрчлөлтийг хийх боломжтой байх.

#### **Дөрөв. Удирдлагын системд тавих техникийн шаардлага**

- 4.1. Сүлжээний орчинд ажилладаг байх;
- 4.2. Интернет хөтчийг дэмжин ажилладаг байх;
- 4.3. Системд нэвтрэх эрхийн дагуу нууцлалтай ханддаг байх;
- 4.4. Бусад системтэй мэдээлэл солилцдог байх;
- 4.5. Удирдлагын систем нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн сан, мэдээлэл түүнийг дэмжих дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх;
- 4.6. Хэрэглэгчдэд нууц үг олгох, сэргээх боломжтой байх;
- 4.7. Пакет болон бусад гадны халдлагаас хамгаалагдсан байх;
- 4.8. Өгөгдлийн санг нөөцөлж хадгалдаг байх;
- 4.9. Хэрэглэгчийн эрхийн зохицуулалттай байх.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн  
А/III тушаалтын хоёрдугаар хавсралт



## СУРАЛЦАХУЙН УДИРДЛАГЫН СИСТЕМД ТАВИХ ШААРДЛАГА

### Нэг. Ерөнхий зүйл

1.1.“Суралцахуйн удирдлагын систем” гэж сургалтын агуулга, контентыг хургэх, зайн сургалтын үйл явцыг зохион байгуулах, суралцагчийн ахиц дэвшилийг хянах, тайлагнах үйл ажиллагааг зохицуулах зориулалт бүхий программ хангамжид суурилсан мэдээллийн системийг хэлнэ.

1.2. Төрийн болон төрийн бус өмчийн бүх түвшний сургалтын байгууллага болон мэдээлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийн сургалт, үйл ажиллагаанд зориулан хөгжүүлсэн суралцахуйн удирдлагын систем нь энэхүү шаардлагад нийцсэн байна.

1.3. Энэхүү системд цахим контент шинээр үүсгэж байршуулсан этгээд нь хууль, тогтоомжийн дагуу түүний өмчлөгч байна.

### Хоёр. Суралцахуйн удирдлагын системд тавих үндсэн шаардлага

Суралцахуйн удирдлагын систем нь сургалт зохион байгуулалт, цахим контент, үнэлгээ, гэрийн даалгавар, суралцагчийн удирдлага, багшийн удирдлага гэсэн бүрдэл хэсэгтэй байна.

2.1. Сургалт зохион байгуулалтын хэсэгт тавих шаардлага.

2.1.1 сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах хичээлийн хуваарийг үүсгэх;

2.1.2 сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан заавал болон сонгон судлах хичээл, судлах нийт цаг (7 хоног, жил)-ийг бүртгэх;

2.1.3 үнэлгээний арга, хэрэгсэл, шалгуурыг бүртгэх боломжтой байх;

2.1.4 хичээл бүрийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн (биет болон зурагт үзүүлэн, хэвлэмэл материал, туршилт, дадлагын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл)-ий жагсаалт болон нээлттэй эх сурвалжийн холбогдох линкийг бүртгэх боломжтой байх;

2.1.5 дижитал үзүүлэн, цахим ном, сурх бичиг, гарын авлагыг файл хэлбэрээр байршуулах боломжтой байх;

2.1.6 суралцахуйн зорилтыг хичээл, анги бүрээр бүртгэх боломжтой байх;

2.1.7 анги, бүлэг бүрийг бүртгэх, суралцагчийн анги бүлэгт хуваарилах боломжтой байх;

2.1.8 цахим хичээл зохион байгуулах боломжтой байх; (Жишээ нь zoom, Microsoft teams, Google meet гэх мэт программ хангамж ашиглан онлайн хичээлийг зохион байгуулдаг байж болно).

## 2.2. Цахим контентын хэсэгт тавих шаардлага

2.2.1 суралцахуйн удирдлагын системд байршуулах цахим сурах бичиг, сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, цахим хичээл нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан шаардлагад нийцсэн байх;

2.2.2 багшийн боловсруулсан цахим контент, нээлттэй эх материал болон бусад нөөц ашиглан бэлтгэсэн файл, зураг, аудио, видеог байршуулах боломжтой байх;

2.2.3 цахим контентын санг сургалтын байгууллага болон багш өөрөө тус тус үүсгэх боломжтой байх;

2.2.4 контентын сан нь хайлтын функцтэй байх.

## 2.3. Үнэлгээ, гэрийн даалгаврын хэсэгт тавих шаардлага

2.3.1 хичээлийн явцын болон улирал, жилийн эцсийн үнэлгээг бүртгэх боломжтой байх;

2.3.2 гэрийн даалгаврын функцтэй байх (бие даан ажиллах дасгал, даалгаврыг оруулах, холбогдох файл хавсаргах боломжтой);

2.3.3 гэрийн даалгаврыг суралцагч тухайн системийг ашиглан гүйцэтгэх боломжтой байх;

2.3.4 гэрийн даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх, хариу мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх боломжтой байх.

## 2.4. Суралцагчийн удирдлагын хэсэгт тавих шаардлага

2.4.1 хичээлд бүртгүүлэх хүсэлт гаргах, цуцлах боломжтой байх;

2.4.2 бүртгүүлсэн хичээл, контентыг харах боломжтой байх;

2.4.3 судалсан хичээлийн түүхийг харах боломжтой байх;

2.4.4 ирцийн болон дүнгийн мэдээллээ харах боломжтой байх;

2.4.5 системд байршуулсан контентод үнэлэлт, дүгнэлт өгөх боломж олгосон байх;

2.4.6 гүйцэтгэсэн дасгал, даалгаврыг илгээх болон нэмэлт файл хавсаргах боломжтой байх.

## 2.5. Багшийн удирдлагын хэсэгт тавих шаардлага

2.5.1. удирдсан анги, бүлгийн суралцагчийн мэдээллийг бүртгэх, өөчлөх, хянах боломжтой байх;

2.5.2. хичээл зааж байгаа анги, бүлгийн суралцагчийн дүнг бүртгэх, засах, хянах, илгээх боломжтой байх;

2.5.3. гэрийн даалгавар үүсгэх, дүгнэх, илгээх боломжтой байх;

2.5.4. даалгаврын сан үүсгэх, ашиглах боломжтой байх;

2.5.5. шалгалт зохион байгуулах, явцыг хянах, удирдах боломжтой байх (сорил, явц, улирлын шалгалт);

2.5.6. шалгалтын үр дүнг харуулах, тайлан гаргах, шинжилгээ хийх боломжтой байх.

## **Гурав. Суралцахуйн удирдлагын системд тавих тусгай шаардлага**

- 3.1 Систем хэрэглэгчийн бүртгэл, баталгаажуулалт хийх боломжтой байх;
- 3.2 Хэрэглэгчийн эрхийг тохируулах, түдгэлзүүлдэг байх;
- 3.3 Хэрэглэгчийн системд хийх үйлдлүүдийг тохируулдаг байх;
- 3.4 Сургалтын үйл ажиллагааны тайлан гардаг байх;
- 3.5 Тайллан экспорт хийдэг байх;
- 3.6 Системийн хайлтын функцтэй байх;
- 3.7 Хэрэглэгчийн интерфейс нь Монгол хэл дээр байх;
- 3.8 Суралцахуйн удирдлагын систем нь ашиглах заавар, гарын авлагатай байх;
- 3.9 Удирдлагын системд ашиглагдаж байгаа нэр томъёог боловсролын салбарт хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичигт заасан агуулгаар ойлгож хэрэглэх бөгөөд нэр томъёо өөрчлөгдөх тохиолдолд системд холбогдох өөрчлөлтийг хийх боломжтой байх.

## **Дөрөв. Суралцахуйн удирдлагын системд тавих техникийн шаардлага**

- 4.1 Сүлжээний орчинд ажиллах боломжтой байх;
- 4.2 Интернэт хөтчийг дэмжин ажилладаг байх;
- 4.3 Системд нэвтрэх эрхийн дагуу нууцлалтай ханддаг байх;
- 4.4 Бусад системтэй мэдээлэл солилцдог байх;
- 4.5 Суралцахуйн удирдлагын системийн хэрэглэгчийн интерфейсүүдийг WCAG /Web Content Accessinility Guidlines/ стандартад нийцүүлэн хөгжүүлсэн байх;
- 4.6 Суралцахуйн удирдлагын систем нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн сан, мэдээлэл түүнийг дэмжих дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах боломжтой байх;
- 4.7 Хэрэглэгчдэд нууц үг олгох, сэргээх боломжтой байх;
- 4.8 Пакет болон бусад гадны халдлагаас хамгаалагдсан байх;
- 4.9 Өгөгдлийн санд хадгалах мэдээллийг шифрлэх боломжтой байх;
- 4.10 Өгөгдлийн санг нөөцөлж хадгалдаг байх;
- 4.11 Хэрэглэгчийн эрхийн зохицуулалттай байх;